

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

I. Ерөнхий нөхцөл

1. **Smartbot.mn** нь “Перфект Пакт” ХХК-ийн өмч бөгөөд харилцагчийн харилцааг автоматжуулах ухаалаг чатбот систем юм. Энэхүү үйлчилгээний нөхцөл нь хэрэглэгч Smartbot.mn системийг ашиглах явцад үүсэх талуудын эрх, үүрэг, хариуцлага болон харилцааг зохицуулахад оршино.
2. Хэрэглэгч нь Smartbot.mn системд бүртгэл үүсгэсэн үеэс эхлэн тухайн бүртгэл хаагдах хүртэл энэхүү үйлчилгээний нөхцөл хүчин төгөлдөр үйлчилнэ.
3. Хэрэглэгч Smartbot.mn системийг ашигласнаар энэхүү үйлчилгээний нөхцөлийг бүрэн хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно.

II. Хэрэглэгчийн анхаарах зүйлс

1. Smartbot.mn ухаалаг чатбот систем нь Facebook, Messenger, Instagram, WhatsApp, Telegram, Viber, Website, Google Business, мессеж зэрэг олон нийтийн болон харилцааны платформуудтай холбогдон ажиллах боломжтой.
2. Хэрэглэгч өөрийн үүсгэсэн болон байгууллагын системтэй интеграц хийсэн ухаалаг чатботоор дамжуулан түгээж буй мэдээлэл, харилцан яриа, дата солилцоо болон бусад агуулгын үнэн зөв, хууль ёсны байдалд өөрөө бүрэн хариуцлага хүлээнэ.
3. Хэрэглэгчийн чатботоор дамжуулан гуравдагч этгээдэд хүргэсэн мэдээлэл, санал, бүтээгдэхүүн үйлчилгээ, харилцаа болон түүнээс үүдэх аливаа маргаан, хохирол, хариуцлагыг “Перфект Пакт” ХХК хариуцахгүй.
4. Smartbot.mn систем дээр үүссэн хэрэглэгчийн account, системийн холболтын мэдээлэл, чатботын тохиргоо болон мэдээллийн нууцлалыг “Перфект Пакт” ХХК хуульд заасны дагуу хамгаалах бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй.
5. Хэрэглэгч нь нэг account дээр нэг болон түүнээс дээш олон нийтийн платформыг холбох боломжтой. Нэг платформын хаягийг давхардуулан холбох боломжгүй.
6. Хэрэглэгч нь зөвхөн өөрийн эзэмшдэг, удирдах эрхтэй буюу admin эрх бүхий платформын хуудас, суваг, хаягийг Smartbot.mn системтэй холбох үүрэгтэй.
7. Хэрэглэгч ухаалаг чатботоор дамжуулан харилцааны платформын хэрэглэгчидтэй харилцах явцдаа Монгол Улсын хууль тогтоомж, тухайн платформын үйлчилгээний нөхцөл болон нууцлалын бодлогыг мөрдөнө.
8. Ухаалаг чатбот ашиглан дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:
 - а. Залилан мэхлэх шинжтэй, худал, гүтгэлгийн, бусдын нэр төр, алдар хүндэд халдсан, доромжилсон болон оюуны өмчийн эрх зөрчсөн мэдээлэл оруулах, түгээх;

- b. Байгууллага болон хувь хүний нууцад хамаарах мэдээллийг зохих зөвшөөрөлгүйгээр цуглуулах, хадгалах, дамжуулах, түгээх;
 - c. Харилцааны платформын хэрэглэгчээс хувийн мэдээлэл, санхүүгийн мэдээлэл, нэвтрэх нэр, нууц үг болон бусад эмзэг мэдээллийг хууль бус буюу зөвшөөрөлгүйгээр шаардах;
 - d. Монгол Улсын хууль тогтоомж, олон нийтийн ёс зүй болон тухайн платформын дүрэм, журмаар хориглосон аливаа үйлдэл хийх;
 - e. Спам, хуурамч санал, зөвшөөрөлгүй сурталчилгаа, хэрэглэгчийг төөрөгдүүлэх агуулга түгээх.
9. Smartbot.mn систем дээр хэрэглэгчийн үүсгэсэн чатбот нь Meta болон бусад платформтой мэдээлэл солилцох зарчмаар ажилладаг тул хэрэглэгч тухайн платформуудын үйлчилгээний нөхцөл, хөгжүүлэгчийн бодлого, нууцлалын журам болон хэрэглэгчийн мэдээлэл боловсруулах шаардлагыг мөрдөх үүрэгтэй.
 10. Хэрэв хэрэглэгч Meta болон бусад платформын үйлчилгээний нөхцөл, бодлого, дүрэм журамд үл нийцэх үйл ажиллагаа явуулсан тохиолдолд Smartbot.mn нь хэрэглэгчийн чатботын үйл ажиллагааг түр зогсоох, холболтыг салгах, үйлчилгээг цуцлах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.
 11. Хэрэглэгч нь Smartbot.mn системийн нэвтрэх эрх, хандах эрх, удирдах эрх, account-ийн мэдээлэл, нууц үг болон холболтын мэдээллээ бусдад дамжуулахгүй байх үүрэгтэй.
 12. Хэрэглэгч өөрийн нэвтрэх эрх, account-ийн мэдээллээ алдсан, гуравдагч этгээдэд ашиглуулсан, эсвэл хамгаалалтын үүргээ биелүүлээгүйн улмаас үүссэн аливаа хохирол, эрсдэлийг “Перфект Пакт” ХХК хариуцахгүй.
 13. Хэрэв хэрэглэгч өөрийн account-ийн нууцлал алдагдсан гэж үзвэл нэн даруй нууц үгээ солих, эсвэл info@smartbot.mn цахим шуудан, бүртгэлийн систем болон **7211-4700** дугаараар холбогдон мэдэгдэх үүрэгтэй.

III. Төлбөрт үйлчилгээ авах, цуцлах

1. Smartbot.mn систем нь хэрэглэгчдэд үнэ төлбөргүй ашиглах боломжуудыг санал болгохоос гадна нэмэлт төлбөртэй үйлчилгээ үзүүлж болно.
2. Төлбөрийн гарц, байгууллагын систем, API болон бусад тусгай интеграц холбох тохиолдолд талууд тусдаа гэрээ байгуулах шаардлагатай.
3. Нэг удаагийн төлбөрт үйлчилгээ нь үндсэн үйлчилгээний төлбөрөөс тусдаа тооцогдоно. Үүнд дараах үйлчилгээ багтаж болно:
 - a. Нэмэлт блок, урсгал, автоматжуулалт үүсгэх;
 - b. Shop цэсэнд бараа, бүтээгдэхүүн оруулах;

- c. Google Sheets холболт, тохиргоо хийх;
 - d. Платформын холболт, тохиргоо хийх;
 - e. Boost хийх зааварчилгаа өгөх;
 - f. Байгууллагын дотоод системтэй холбох нэмэлт хөгжүүлэлт хийх;
 - g. Тухайн хэрэглэгчийн хэрэгцээнээс хамаарсан бусад нэмэлт ажил.
4. Нэмэлт төлбөрт үйлчилгээний тариф Smartbot.mn сайтад нээлттэй байж болно. Гүйцэтгэх ажлын цар хүрээ, төвөгшил, хугацаанаас хамааран үйлчилгээний үнэ өөр өөр байна.
 5. Хэрэглэгч өөрийн холбосон платформ тус бүрээр үйлчилгээний төлбөр төлөх боломжтой.
 6. Үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэл нь үйлчилгээний хугацаа дуусахаас **1–7 хоногийн өмнө** хэрэглэгчийн бүртгэлтэй утасны дугаар болон/эсвэл бусад бүртгэлтэй холбоо барих сувгаар илгээгдэнэ.
 7. Үйлчилгээний хугацаа дуусахад төлбөр төлөгдөөгүй тохиолдолд хэрэглэгчийн ухаалаг чатботын үйлчилгээ, системд хандах эрх болон холбогдох ажиллагааг түр хааж болно.
 8. Ухаалаг чатботын үйлчилгээ түр хаагдсанаас хойш **15 дахь хоногт** үйлчилгээ цуцлагдана. Үйлчилгээ цуцлагдсанаар харилцан ярианы түүх, ботын бүтэц, тохиргоо, платформ дээрх дата болон холбогдох мэдээлэл сэргээх боломжгүйгээр устаж, платформуудын холболт салгагдана.
 9. Хэрэглэгч хүссэн үедээ үйлчилгээг цуцлах боломжтой. Энэ тохиолдолд үйлчилгээ цуцалсан өдрөөс хойших үлдэгдэл хоногийн төлбөрийг буцаан олгохгүй.
 10. Хэрэглэгч өөрийн хүсэлтээр үйлчилгээг цуцалсан тохиолдолд харилцан ярианы түүх, ботын бүтэц, тохиргоо, платформ дээрх дата болон холбогдох мэдээлэл сэргээх боломжгүйгээр устах бөгөөд үүнээс гарах үр дагаврыг “Перфект Пакт” ХХК хариуцахгүй.

IV. Сувгийн холболт салгах, ухаалаг чатбот устгах болон account хаах

1. Хэрэглэгч нь Smartbot.mn системийн удирдах хэсгээс холбосон платформын хаяг, суваг, хуудсаа өөрөө салгах буюу устгах боломжтой.
2. Хэрэглэгч холбосон платформын хаягаа устгасны дараа шаардлагатай тохиолдолд шинэ хаяг, суваг, хуудсаар солих боломжтой.
3. Хэрэглэгч холбосон хаяг, суваг, хуудсаа устгасан тохиолдолд тухайн платформтой холбоотой харилцан ярианы түүх, ботын бүтэц, тохиргоо, платформ дээрх дата болон холбогдох мэдээлэл сэргээх боломжгүйгээр устаж болзошгүй.

4. Хэрэглэгч account-аа хаах хүсэлт гаргасан тохиолдолд Smartbot.mn нь хэрэглэгчийн хүсэлтийг хүлээн авч, холбогдох мэдээллийг устгах, үйлчилгээний холболтуудыг салгах, account-ийг идэвхгүй болгох арга хэмжээ авна.
 5. Account хаагдсанаас үүдэн гарах өгөгдөл устгах, холболт салгах болон үйлчилгээ ашиглах боломжгүй болох үр дагаврыг хэрэглэгч өөрөө хариуцна.
-

V. Бусад

1. Энэхүү үйлчилгээний нөхцөлд “Перфект Пакт” ХХК-ийн үйлчилгээний шинэчлэлт, хууль эрх зүйн шаардлага, системийн хөгжүүлэлт болон бизнесийн үйл ажиллагааны өөрчлөлтөөс хамааран нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
2. Үйлчилгээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд Smartbot.mn нь үйлчилгээ авч буй хэрэглэгчдэд цахим шуудан, системийн мэдэгдэл болон/эсвэл бусад боломжит сувгаар урьдчилан мэдэгдэнэ.
3. Хэрэглэгч үйлчилгээний нөхцөл шинэчлэгдсэний дараа Smartbot.mn системийг үргэлжлүүлэн ашигласан бол шинэчилсэн нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.